

Шинэ Өмнөд Уэльс (NSW) мужийн улсын сургуулиудын “Өндөр чадвар, авьяас бүхий сурагчдад зориулсан боловсрол” хөтөлбөр – Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан гарын авлага

Шинэ Өмнөд Уэльс мужийн улсын сургуулиудад суралцаж буй бүх сурагч бүрийн өөрийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн сонирхолтой мөн сорилт бүхий суралцах үйл явцад оролцох боломжийг хангах зорилгоор Өндөр чадвар, авьяас бүхий сурагчдад зориулсан боловсролын хөтөлбөр (High Potential and Gifted Education (HPGE))-ийг хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөрийн хүрээнд сурагчдын чадавхийг дараах дөрвөн үндсэн чиглэлээр хөгжүүлэхэд төвлөрдөг: бүтээлч, оюунлаг, бие бялдрын хөгжил болон нийгэм-сэтгэлзүй.

Чадавхийн үндсэн дөрвөн төрөл:

Чадавхийн үндсэн төрөлд хувь хүний төрөлх авьяас чадварын 4 үндсэн шинж чанарууд багтдаг. Эдгээр нь ихэнхдээ хоорондоо давхцаж, харилцан нөлөөлдөг шинж чанартай байдаг. Эдгээр чиглэл нь:

Бүтээлч чадавхи – төсөөлөл, өвөрмөц байдал, шинэ санаа гаргах чадварыг хэлнэ. Энэ чадвар нь хүүхдийн бичсэн өгүүллэг, зохиосон дуу, зурсан зурагт хуудас, математикийн бодлогын өвөрмөц шийдэл, бүжгийн зохиомж зэргээс харагдаж болно.

Оюунлаг чадавхи – төвөгтэй ойлголтыг ойлгох, асуудал шийдэх, мэдлэгээ ашиглах чадварыг хэлнэ. Жишээлбэл, хүүхэд аливааг хурдан амархан сурах, философи, шинжлэх ухаан эсвэл ном зохиолыг гүнзгий ойлгодог байж болно.

Бие бялдрын чадавхи – хүний хөдөлгөөний төрөлх чадварыг хэлнэ. Энэ нь жишээлбэл, биеийн тамир спортын, гар урлал, мужааны ажил, инженерчлэл зэрэг үйл явцад илэрдэг. Эдгээр чадварыг анги танхим, тоглоомын талбай, мөн түүнчлэн сургуулийн гадуурх хөтөлбөрүүд, олон нийтийн уралдаан, арга хэмжээнүүд дээр ажиглаж болно.

Нийгэм-сэтгэлзүйн чадавхи – сэтгэл хөдлөлөө зохицуулах, бусадтай харилцах чадварыг хэлнэ. Энэ нь ангийн хүүхдүүд, багш нар, эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах харилцаанаас харагдаж болно. Жишээлбэл, хүүхэд өөртөө итгэлтэй байх, бусдыг манлайлах, хамтран ажиллах чадвартай, эсвэл бизнес сэтгэлгээтэй байх гэх мэт.

Өндөр чадвар, авьяас бүхий сурагчдыг сургууль хэрхэн дэмждэг вэ

Хүүхэд бүрийн чадавхи өөр өөр байдаг тул төрөл бүрийн хэлбэрийн дэмжлэг, сургалт шаардлагатай байж магадгүй байдаг. Жишээлбэл:

Өндөр чадвар, авьяас бүхий сурагчид нь тухайн насныхантайгаа харьцуулахад илүү өндөр чадамжтай байдаг ба илүү сорьсон үүрэг даалгаврууд өгөх нь тэдэнд илүү үр өгөөж өгдөг.

Авьяастай сурагчид нь тухайн насныхантайгаа харьцуулахад маш өндөр чадвартай бөгөөд хэрэв тэдэнд боломжийг нь бий олгож өгвөл тэдний энэ ур чадвар хурдан, хялбар хөгждөг.

Онцгой авьяастай сурагчид нь маш өндөр түвшний чадвартай байх ба тэдний уг суралцах хэрэгцээнд нийцүүлэн сургалтын орчныг үлэмж хэмжээгээр тохируулах шаардлагатай болдог.

Сургуулиуд өндөр чадвар, авьяастай сурагчдыг дараах төрөл бүрийн сургалтын арга барил, хөтөлбөрүүдээр дэмждэг. Үүнд:

- сурагчдыг урамшуулж, сорьсон хичээлүүд явуулах
- төрөл бүрийн соёл урлаг спортын арга хэмжээнүүд ба сургуулийн гадуурх хөтөлбөрүүд
- адил төстэй чадавхи бүхий сурагчдыг бүлгээр сургах
- боломжтой тохиолдолд хичээлийн хөтөлбөрийг түргэсгэх зэргээр ахисан түвшний суралцах замуудыг бий болгох
- сурагчдын сайн сайхан байдал болон нийгмийн ур чадварыг хөгжүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх.

Хөтөлбөрийн зорилго нь шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик, хэл, урлаг, спорт, манлайлал эсвэл бусад салбаруудад өндөр чадавхи бүхий сурагчдыг өндөр гүйцэтгэлтэй болоход нь туслах явдал юм.

Сурагч бүр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой

Өндөр чадвар, авьяас бүхий сурагчид өөр үндэс угсааны, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл өөр хэл соёлын бүлгээс ч ирсэн байж болно. Зарим нь сургуульдаа хурдан сайн амжилт гаргаж чаддаг бол заримд нь ингэхийн тулд нэмэлт тусламж шаардлагатай байдаг. Авьяастай сурагчдад дэмжлэг хэрэггүй гэсэн буруу ойлголт байдаг ч үнэндээ хичээлдээ сонирхолтой байж, сайн сурахын тулд тэдэнд тусгай дэмжлэг хэрэгтэй байж болох юм.

Хүүхэд тань өндөр чадавхитай эсвэл авьяастай байж болзошгүй гэж бодож байвал та юу хийвэл зохих вэ?

Хэрэв та хүүхдээ өндөр чадавхитай эсвэл авьяастай байж болзошгүй гэж бодож байвал хүүхдийнхээ багштай энэ талаар ярилцаарай. Багштай ярихдаа таны хүүхдийн гаргаж буй ямар үйлдэл түүний өндөр чадавхи эсвэл авьяастай байгааг харуулж байгааг жишээгээр хэлж өгөөрэй.

Хүүхдийнхээ суралцах үйл явцад идэвхтэй оролцож, хүүхдийнхээ талаар мэдээлэл санал бодлоо хуваалцаж, сургуултай хамтран ажилласнаар эцэг эх, асран хамгаалагчид чухал үүрэг гүйцэтгэдэг.

HPGE-ийн бодлого

[Өндөр чадавхи, авьяас бүхий сурагчдад зориулсан Боловсролын Бодлого](#) (HPGE) нь Шинэ Өмнөд Уэльс мужийн улсын бүх сургуулиудад хэрэгждэг. Энэ бодлогын хүрээнд багш нарт өндөр чадавхи, авьяас бүхий сурагчдын хэрэгцээг тодорхойлж үнэлэх, мөн түүнчлэн тэдэнд өсч хөгжих, амжилт гаргах боломж олгоход нь тусладаг болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг хаанаас авах вэ?

- NSW мужийн улсын бүх сургуулиуд HPGE хөтөлбөрийг санал болгодог. Дэлгэрэнгүй мэдээллийг хүүхдийнхээ сургуулийн вэбсайтаас авна уу.
- Сургуулийн зүгээс өндөр чадавхи, авьяас бүхий сурагчдыг хэрхэн дэмждэг талаар хүүхдийнхээ багш нартай ярилцахыг хүсч болно.
- Холбогдох бодлого, нөөц мэдээлэлтэй нэмж танилцахыг хүсвэл [Боловсролын яамны Өндөр Чадавхи, Авьяас бүхий Сурагчдад зориулсан Боловсрол](#) вэб сайтад зочилно уу.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хүүхдийнхээ сургуультай өндөр чадавхи, авьяас бүхий сурагчдад зориулсан боловсролын талаар хүүхдийнхээ сургуультай орчуулагчийн тусламжтайгаар ярилцахыг хүсвэл 131 450 дугаарт залгана уу. Операторт аль хэлний орчуулагч хэрэгтэйг хэлж, сургууль руу залгахыг хүснэ үү.

Оператор таны хэлээр ярьдаг орчуулагчийг шугаманд холбож туслах бөгөөд энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.